

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
1.1	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сулжээ (фэйсбуук, твитер, инстаграм youtube суваг), мөн байгууллагуудын TV-ийн дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.	-	Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо,	500 иргэнээс доошгүй	Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд "Хужирт сум Авлигын эсрэг НЭГДБЕ" үндэсний хэмжээний нөлөөллийн аяны хүрээнд хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдэлийг бууруулж, иргэдийг авлигын эсрэг шүгэл үлээхэд түлхэц үзүүлэх зорилготой сумын khujirt.ov.gov.mn вэбсайтад байршуулсан "Хужирт сум Авлигын эсрэг НЭГДБЕ" үндэсний хэмжээний нөлөөллийн аяны зурагт хуудсыг 315, Авлигатай тэмцэх газраас хийсэн "Буруу аргаар олж авсан баялаг бүтэн амьдралыг ч сүйрүүлнэ" шторкийг 50, "Шүгэл Үлээцгээе-Авлигын Эсрэг Нэгдье" шторкийг 41, "Авлигад дасах хэрэггүй -Авлигад үгүй гэж хэлээд өөрчилье" шторкийг 49 иргэн үзсэн тандалттай байна. Мөн Засаг даргын Тамгын газрын 4762 гишүүнтэй Facebook групп "Авлигын эсрэг НЭГДБЕ" аянд нэгдэж, Cover зургийг шинэчилж, Авлигатай тэмцэх газраас гаргасан 10 төрлийн шторкийг байршуулж, нийт 1804 иргэн үзсэн тандалттай байна. Сумын khujirt.ov.gov.mn вэбсайтын Ил тод байдал цэсийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэсгийн Авлигатай тэмцэх хөтөлбөрийн суманд хамаарах заалт хэсэгт 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг байршуулсан. Үр дүнтэй-100%
1.2	1.2. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110"	-	Шинэчилсэн мэдээллийн тоогоор	Сар бүр шинэчилэх	"Шударга ёс, хөгжил дэвшилд 110" гомдол, мэдээлэл хүлээж авах хайрцгийг Засаг даргын Тамгын газарт байршуулж ажиллаж байна. Ямар нэг гомдол, мэдээлэл ирээгүй байна.

	мэдээллийн ажиллуулах.	самбар				Мөн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт иргэдэд түгээх авлигын эсрэг зурагт 4 янзын хуудсыг байршуулан түгээж байна. Үр дүнтэй -100%
Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах						
2.1	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	840,0	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Шинэ томилогдсон албан хаагчид		Шинээр томилогдсон болон мэдүүлэг анх гаргаж буй 14 албан хаагч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, ХАСУМ, ХАСХОМ-ийг хэрхэн гаргах талаарх зөвлөгөөг өгсөн. Сонгуулийн үр дүнгээр томилогдсон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга, хурлын ажлын албаны албан хаагчид, төлөөлөгчид аймагт танхимын болон цахим сургалтад хамрагдсан. Энэ онд ХАСХОМ гаргасан нийт 62 эрх бүхий албан тушаалтан, албан хаагч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хуулийн хугацаанд мэдүүлгээ гаргасан. Үр дүнтэй-100%
Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох						
3.1	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээр бүрт ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдүүлгийг авсан байх.	-	Мэдүүлгийн тоогоор	20 доошгүй гэрээнд тусгасан байна		Төрийн албан хаагчдыг ёс зүйн, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үүднээс сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын ажилд томилох, чөлөөлөх, хөрөнгө зарцуулах, ажлын хэсэг байгуулах, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, дуудлага худалдаа явуулах тухай зэрэг захирамж, тушаал гаргах, Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудад тендер шалгаруулах үнэлгээний хороонд орж ажиллах албан хаагчдыг тухай бүр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдүүлгийг бөглүүлэн хяналт тавин ажиллаж хэвшсэн. Энэ онд нийт 166 ашиг сонирхлын мэдүүлэг бөглөгдсөн. Үр дүнтэй-100%
Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах						
4.1	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил	5000.0	Цахимжуулсан үйлчилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо	400-гаас доошгүй иргэнд үзүүлсэн байна		Төрийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төсвийн хөрөнгө 5 сая төгрөгөөр ХУРДАН төрийн үйлчилгээний ГЭРЭГЭ киоск машиныг Засаг даргын Тамгын газарт 6 дугаар сард суурилуулснаар системээс 87 байгууллагын 1263 үйлчилгээг

	тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх /				цахимаар хурдан, хялбар, хүртээмжтэй авах боломж бүрдэж, иргэдийн өдөр тутмын хэрэглээ болоод байна. Тайлант онд нийт оператор системээс 1-6 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 466, ХУРДАН төрийн үйлчилгээний ГЭРЭГЭ киоск машинаас 6 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл 475 буюу нийт 941 иргэн үйлчилгээг авсан. www.egazar.gov.mn системээр дамжуулан газартай холбоотой бүх үйлчилгээг авах боломжтой талаар өөрийн цахим хуудас болон Хужирт сумын газрын даамал page, Засаг даргын Тамгын газрын page-г сурталчилсан. Үүний үр дүнд энэ онд нийт 172 цахим хүсэлт ирүүлсэнээс хавсралт материал бүрэн, шаардлага хангасан 80 хүсэлтийг хүлээн авч шинээр өргөдөл үүсгэн бүрэн шийдвэрлэсэн. 92 хүсэлт нь хавсралт материал буруу оруулсан болон давхардаж илгээсэн учир цуцалж хариу мэдэгдэл хүргэж ажилласан. Үр дүнтэй-100%
4.2	Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Сэтгэл ханамжийн судалгаа авах	Сэтгэл ханамжийн судалгаа аваагүй Үр дүнгүй-0
Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хусэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх					
5.1	Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах.		Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулснаар	Нийт алба хаагчдад танилцуулсан байна	Сумын khujirt.ov.gov.mn вэбсайтын Ил тод байдал цэсийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэсгийн Авлигатай тэмцэх хөтөлбөрийн суманд хамаарах заалт хэсэгт 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 6 бүлэг, 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргаар баталгаажуулж байршуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувьтай биелэгдсэн. Мөн байгууллага бүр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн байгууллагад хамааралтай заалтаар төлөвлөгөө гарган, холбогдох байгууллагад хагас, бүтэн жилээр тайланг хүргүүлж ажилласан. Үр дүнтэй-100%
5.2	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тухай бур	Авлигатай тэмцэх газраас эрх бүхий албан тушаалтанд анхааруулсан зөвлөмж 1, Сонгуулийн ерөнхий хороотой хамтран

	зүйн дүрэм, зөвлөмжийг хэрэгжүүлэх.				<p>бэлтгэсэн 12 бичлэг, бусад 3 нийт 15 бичлэгийг сумын вэб сайт, Засаг даргын Тамгын газрын Facebook группэд байршуулж, иргэдэд түгээж ажилласан.</p> <p>ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн батлах төсөлд санал өгсөн.</p> <p>УИХ-ын байнгын хорооны 2024 оны "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоол, хавсралттай танилцсан.</p> <p>Авлигатай тэмцэх газрын эрх бүхий албан тушаалтанд зориулсан мэдээ, мэдээлэл түгээх Facebook-ийн ЭБАТ группэд цаг үетэй холбоотой тавигдсан мэдээлэл, шинэчлэн батлагдсан журам, маягттай тухай бүрт нь танилцаж ажилдаа ашиглаж байна.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй-100%</p>
Зорилт 6. Байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах					
6.1	Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй зүйл заалтад орсон өөрчлөлтийн талаар аймгийн Прокурорын газар, авлигын эсрэг сургагч багш нарын хамтран зохион байгуулах сургалтад төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг сургалт, мэдээлэл өгч, зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлэх.	0.4	Зохион байгуулсан сургалтын тоо	20 доошгүй удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан	<p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Орон нутаг дахь авлигын нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчлан таниулах танхим, цахим сургалтад сумын ИТХ-ын дарга, хурлын ажлын албаныхан болон төлөөлөгчид, Засаг дарга, Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нар хамрагдсан.</p> <p>Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан сургалтад 2 улсын байцаагч хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Үр дүнд хүрсэн-100%</p>
6.2	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд хяналт тавьж, тайланг хүргүүлэх.	-	Хуулийн хугацаанд хүргүүлсэн байдлаар	Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байна.	<p>Хууль бус томилгоо хийгдээгүй.</p> <p>Шинээр томилогдох 3 албан хаагчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлтийг үндэслэн томилосон.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй-100%</p>

6.3	Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх уйл ажиллагааг хүүхэд залуучуудад хүргэх ажлыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан иргэн, хүүхэд залуучуудын тоо	350	Авлигатай тэмцэх газраас гаргасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мэдээ мэдээллийн талаарх телевизийн 14 төрлийн мэдээлэл зөвлөгөө шторк, хэвлэн олшруулж байршуулах 6 төрлийн материал, FM радиогийн буюу сонсох гэх мэт нийт 23 зөвлөгөө мэдээллийг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд байгууллагынхаа мэдээллийн самбарт байршуулах, телевизээр танилцуулсан. Үр дүнтэй-100%
НЭГДСЭН ДҮН: 91%					

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Б. ДЭМБЭРЭЛ
 З. ЦЭЦЭГМАА